


Гадаадын иргэн, харьяатын газрын
2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн
01/2243 дугаар албан бичгийн хавсралт



ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН 2025 ОНЫ ТАЙЛАН

Д/д	Шийдвэрийн нэр, огноо,	Зүйл, заалт ын дугаар	Зүйл, заалтын агуулга	Хэрэгжилтийн тайлан	Хэрэгжилтийн хувь	Хэрэгжээгүй шалтгаан	Хяналтаас хасах үндэслэл
1	2	3	4	5	6	7	8
Монгол Улсын хууль							
1.	Төсвийн тухай /Шинэчилсэн найруулга/ 2011-12-23 Дугаар 2015-10	14.2.1 1.	Төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад 3-5 жил тутамд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулах;	Гадаадын иргэн, харьяатын газарт 2025 онд 20,757.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 07 дугаар сард тодотгол хийгдэж 18,844.1 сая төгрөгөөр баталсан. Энэ оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 14,523.0 сая төгрөгийн санхүүжилт авч, зориулалтын дагуу, үр ашигтай зарцуулан 14,357.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан. Төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор байгууллагын даргын 04 дүгээр сарын 11-ний өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 01/736, 01/1594 дүгээр албан бичгийг Хилийн боомт, орон нутагт дахь төсвийн шууд захирагч нарт хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. https://shilendans.gov.mn/	100		
2.	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд	22.2.	Энэ хуулийн 22.1.2-т заасан өвчний жагсаалтыг эрүүл мэндийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн	Монгол Улсад орохыг үл зөвшөөрөх гадаадын иргэний өвчний (нийтийн эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй халдварт өвчнөөр өвчилсөн, өвчилсөн байж болзошгүй шинж тэмдэг илэрсэн этгээд байвал) жагсаалтыг батлаагүй.	0		

1	2	3	4	5	6	7	8
	нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2013-12-26 Дугаар 2015-10		газрын гишүүн хамтран батална.	Нийтийн эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй халдварт өвчөөс урьдчилан сэргийлэх хүрээнд дэлхий нийтэд Улаанбурхан өвчний тархалт нэмэгдэж байгаатай холбогдуулан Эрүүл мэндийн яамнаас 2025 оны 2/999 дүгээр албан бичгээр ирүүлсэн чиглэлийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, хилийн боомтод халдвар хамгааллын дэглэм сахиулан урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллаж байна.			
3.		40.1.5.	Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг ашиглах, мэдээлэл нийлүүлэх, солилцох журмыг хууль зүйн болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	Хууль зүй дотоод хэргийн сайд, Гадаад харилцааны сайдын 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/98, А/25 дугаар хамтарсан тушаалаар “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг ашиглах, мэдээлэл нийлүүлэх, солилцох журам”-ыг баталсныг мөрдөж байна.	100		3.10.1
4.	Төрийн хэмнэлтийн тухай 2022-04-29 Дугаар 2022.04.29	15.2.4.	Цахим гарын үсэг, цахим шуудан ашиглах зэргээр албан бичиг боловсруулах, илгээх үйл явцыг хялбаршуулж бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хор, шуудан хүргэлтийн зардлыг хэмнэх;	Хууль зүй, дотоод хэргийн яамны edoc.mojha.gov.mn цахим сүлжээнд 2024 оноос бүрэн нэвтэрснээр ирсэн, явсан албан бичгийг цахимаар хүлээн авч, шилжүүлэн шуудан холбоо болон бичиг хэргийн зардлыг хэмнэж байна. Түүнчлэн Төрийн сангийн цахим системээр гүйлгээг хийж, цахимжуулснаар бичгийн цаас болон хэвлэгчийн хор, тээвэр шатахууны зардлыг хэмнэн ажиллаж байна. https://edoc.mojha.gov.mn/	100		
5.		15.2.7.	Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх.	Тайлант хугацаанд сургалт, семинар, зөвлөгөөнийг төв байгууллагад танхимаар, хилийн боомт, орон нутаг дахь газар, хэлтэст цахимаар нийт 75 удаагийн арга хэмжээ зохион байгуулахдаа тус бүрд түрээс, шатахуун, томилолтын зардал гаргаагүй бөгөөд албан хаагчдын сургалт хөгжлийн үйл ажиллагаанд 9.5 сая төгрөг зарцуулсан. https://shilendans.gov.mn/	100		
6.		15.2.5.	Хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг	2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар албан хаагчдад холбогдох 1.0 сая төгрөгийн өр төлбөр	100		

1	2	3	4	5	6	7	8
			жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх;	үүссэнийг 2025 оны 01 болон 03 дугаар саруудад бүрэн төлж барагдуулсан. 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар албан хаагчдад холбогдох 1.0 сая төгрөгийн цалингийн өр төлбөр үүссэнийг байгууллагын даргын баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-д тусган, хуваарийн дагуу 2025 оны 01 болон 03 дугаар саруудад бүрэн төлж, өр төлбөрийг барагдуулсан.			
7.	Аялал жуулчлалын тухай 2023-05-04 Дугаар 2023.05.04	18.5.	Хил орчмын нутаг дэвсгэрийн аялал жуулчлалын үйл ажиллагааг зохион байгуулах, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон журмыг Засгийн газар батална.	“Монголд зочлох жил”-ийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн А/314 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус байгууллагаас Виз, зөвшөөрлийн газрын дарга ажиллалаа. Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн “Журам батлах тухай” 142 дугаар тогтоолоор “Хил орчмын нутаг дэвсгэрийн аялал жуулчлалын үйл ажиллагааг зохион байгуулах, аюулгүй байдлыг хангах журам”-ыг баталсан. https://legalinfo.mn/mn/	100		3.10.1
8.		18.2.	Хил орчмын аялал жуулчлалын нутаг дэвсгэрт энэ хуулийн 18.1-д заасан гадаадын иргэн зорчих маршрутыг хууль зүйн болон аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.	Хил орчмын аялал жуулчлалын нутаг дэвсгэрт гадаадын иргэн зорчих маршрутыг хууль зүйн болон аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдээс хамтран батлаагүй байна. Дээрх маршруттай холбоотой Монгол Улсад аялах БНХАУ-ын бүлэг жуулчдын нэрсийн жагсаалтын загварт саналыг 02 дугаар сарын 19-ний өдрийн 02/423 дугаар албан бичгээр Гадаад харилцааны яамны Консулын газарт хүргүүлсэн. Мөн хоёр улсын хоорондын иж бүрэн стратегийн түншлэлийг бэхжүүлэх зорилгоор байгуулсан “Аялал жуулчлалын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн 1.7-д заасны дагуу тус улсын Соёл, аялал жуулчлалын яамнаас Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамаар уламжлуулж 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 7/382 дугаар албан бичгээр ирүүлсэн “Монгол Улсад аялах БНХАУ-ын бүлэг жуулчдын нэрсийн жагсаалт”-ын загварыг	50		

1	2	3	4	5	6	7	8
				судалж үзээд жагсаалт хэлбэрээр олгох КЗ ангиллын визийн загвартай холбогдох саналыг 07 дугаар сарын 22-ны өдрийн 01/1339 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв. Гадаадын иргэн, харьяатын газрын зүгээс олон улсын жишигт нийцүүлэн Монгол Улсад ирэх гадаадын иргэний цахим виз, визийн зөвшөөрлийн үйлчилгээний бүх ангилалд хаягийн баталгаажуулалтыг авах зорилгоор isf.mn, evisa.mn цахим системд 01 дүгээр сарын 17-ны өдрөөс шинэ цонх үүсгэсэн. Мөн Гадаад харилцааны яамнаас 11 дүгээр сарын 06-ны өдрийн 02/5328 дугаар албан бичгээр ирүүлсэн “Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай авах арга хэмжээний тухай танилцуулга”-д Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангахын тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналд хил орчимд аялах “Хятад иргэдийн бүлэг жуулчдын нэрсийн жагсаалт”-ын загварыг баталж, Хятадын талтай дипломат шугамаар тохирох” гэсэн арга хэмжээг тусгажээ. https://isf.mn/mn/ https://www.evisa.mn/			
Хэсгийн дундаж үнэлгээ: 81.2 хувь							
УИХ-ын тогтоол							
9.	Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай 2021-01-22 Дугаар 2021 №12		ХЗДХЯ УИХ-ын тогтоолын төсөл 2021. Монгол Улсад 2021-2024 онд цагаачлуулж болох гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай	Монгол Улсад 2025 оны 11 дүгээр сарын байдлаар хувийн хэргээр оршин суух зөвшөөрөлтэй 37097 гадаадын иргэн, үүнээс хамгийн их буюу БНХАУ-ын 22868 иргэн, цагаачлан оршин суух 1767 гадаадын иргэн, үүнээс хамгийн их буюу БНХАУ-ын 1230 иргэн бүртгэлтэй байгаа нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 27.4, 29.5 дахь хэсэгт заасан хэмжээнээс хэтрээгүй байна. https://opendata.gov.mn/ Монгол Улсад 2009-2012 онд оруулж болох цагаач гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай УИХ-ын 2009 оны 44 дүгээр тогтоолоос хойш тогтоолыг шинэчлэн батлаагүй болно.	100		3.10.3

1	2	3	4	5	6	7	8
				Гадаадын иргэн, харьяатын газраас “Монгол Улсад 2021-2024 онд цагаачлуулж болох гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай” УИХ-ын тогтоолын төсөл, танилцуулгыг 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 01/1730 дугаар, 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 01/2075 дугаар албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлж байсан.			
10.	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2022-07-06 Дугаар 2022 №49	2.а/.	Ажлын байран дахь бэлгийн болон бусад хэлбэрийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох; (2/Жендэрийн эрх тэгш байдал ба хүний эрхийн талаар:)	Байгууллагын “Дотоод журам”-д ажлын байрны дарамттай холбоотой 3 заалтыг тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. Албан хаагчдыг ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах зорилгоор 2 удаагийн санал асуулгыг 05 дугаар сард зохион байгуулж, нийт 190 албан хаагчийг хамруулсан. Судалгааны үр дүнд үндэслэн байгууллагын Жендэрийн эрхийг хангах орон тооны бус зөвлөл нь ажлын байрны бэлгийн дарамтад өртсөн тохиолдолд гомдол мэдээллийг хүлээн авах gender@immigration.gov.mn хаягийг ажиллуулж, энэ оны байдлаар гомдол мэдээлэл бүртгэгдээгүй болно. Түүнчлэн ажлын байрны бэлгийн дарамт, хүчирхийллийн эсрэг мэдээлэл бүхий 4 постер бэлтгэж, erp.e-mongolia цахим системээр байгууллагын хамрах хүрээнд байршуулсныг 144 албан хаагч уншиж танилцжээ.	100		
11.	Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2023-11-10 Дугаар 2023_93	1.10.	Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, ашиглалтад хүлээн авах, өмчид хүлээн авах үйл ажиллагаанд ногоон байгууламжийн стандарт болон тусгай хэрэгцээт иргэдийн хэрэгцээнд нийцсэн стандартыг чанд мөрдөж хэрэгжүүлэх, зохион байгуулах;	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/412 дугаар тушаалаар батлагдсан 2024 оны “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө” дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд “Гадаадын иргэн, харьяатын газрын Баруун бүс дэх газрын үйлчилгээний цогцолбор барилгын шугам сүлжээ” төсөл арга хэмжээг цахим системд нээлттэй сонгон шалгаруулж, тендерт шалгарсан Элбэггүн ХХК-тай гэрээ байгуулсан. Гэрээний хугацаанд цогцолбор барилгын гадна ногоон байгууламж, шугам сүлжээ, цахилгаан холбоо, дулаан, цэвэр бохир усны шугам, тусгай хэрэгцээт иргэнд зориулсан налуу шат, орц, гарц ариун цэврийн өрөөний тохижилтын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллан улсын комиссын	100		3.10.6

1	2	3	4	5	6	7	8
				акт, гэрээ дүгнэсэн актыг үндэслэн санхүүжилтийг бүрэн олгосон.			
Хэсгийн дундаж үнэлгээ: 100 хувь							
УИХ-ын байнгын хорооны тогтоол							
12.	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2023-04-25 Дугаар 2023-05 ТБХ	6г/.	Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын бүх үе шатанд мэргэжлийн судлаачид, мэргэжлийн төрийн бус болон судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах.	Хууль зүйн салбарын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2026 оны төсвийн төсөлд санал авах танхимын хэлэлцүүлгийг 08 дугаар сарын 12-ны өдөр иргэд олон нийтийн оролцоог ханган нээлттэй зохион байгуулсан. Төсвийн гүйцэтгэлийг сар бүр шилэн дансанд олон нийтэд ил тод мэдээлж, Үндэсний аудитын газар төлөвлөлт болон гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.	100		
Хэсгийн дундаж үнэлгээ: 100 хувь							
Ерөнхийлөгчийн зарлиг							
13.	Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58	1.5.	Иргэн, аж ахуйн нэгжийн тарьсан модоор ойн санг бүрдүүлж, түүнийг улсын нэгдсэн санд бүртгэх, тарьсан модыг зах зээлийн эргэлтэд оруулж энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулахад нь бодит дэмжлэг үзүүлэх болон гадаад улсаас Монгол Улсад ирж буй хүн бүр монгол оронд мод тарих санаачилгыг өрнүүлэх	Гадаадын иргэн, харьяатын газар нь “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөнд нэгдэн төв байгууллага болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүд харьяалах нутаг дэвсгэртээ 7 төрлийн 4466 ширхэг мод, сөөг тарьж, усалгаа, арчилгааг хийж байна. Энэ хагас жилд “Бүх нийтээр мод тарих өдөр”-ийг тохиолдуулан төв болон хилийн боомт, орон нутаг дахь газрууд 3 төрлийн 2576 ширхэг мод нэмж тарилаа. Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, Гадаадын иргэн, харьяатын газрын Хойд бүс дэх газар нь 2022 онд Сэлэнгэ аймгийн Шаамар сумын нутаг дэвсгэрт 22500 м2 газрыг хашаалж, байгууллагын нэрэмжит “Төгөл” байгуулан 5 төрлийн 247 ширхэг (агч 60, монос 30, интоор 25, үхрийн нүд 110, алим 22) мод тарьсан бөгөөд 2025 онд нэмж 18 ширхэг гүйлс модны суулгац суулгасан. Монгол Улсад оршин суух зөвшөөрөл хүссэн болон бүртгэл хийлгэж буй гадаадын иргэдэд Монгол оронд мод тарих тухай зөвлөмж, мэдээллийг уриалга хэлбэрээр тогтмол хүргэн ажиллаж байна.	90		
14.		2.	Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа	Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачилж, 2021 оны 58 дугаар зарлигаар баталсны дагуу “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөний хүрээнд Монгол Улсад оршин	100		

1	2	3	4	5	6	7	8
			хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай.	суух зөвшөөрөл хүссэн болон бүртгэл хийлгэж буй гадаадын иргэдэд Монгол оронд мод тарих тухай зөвлөмж, мэдээллийг тогтмол хүргэн 2023 онд уг зөвлөмжийг байгууллагын цахим хуудсанд байршуулж олон нийтэд уриалга хүргэсэн.			
Хэсгийн дундаж үнэлгээ: 96.6 хувь							
Засгийн газрын тогтоол							
15.	Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-09-14 Дугаар 2022_340	1.	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих хууль журмын дагуу хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус үүрэг болгосугай.	Гадаадын иргэн, харьяатын газар нь улсын хилээр нэвтрэх гадаадын иргэнд виз, визийн зөвшөөрөл олгох, бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх, виз болон оршин суух зөвшөөрөлтэй холбоотой зөрчлийг илрүүлэх, хянан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлэхээс гадна гадаад улсын иргэн Монгол Улсын харьяат болох, Монгол Улсын иргэн харьяатаас гарах, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт зөвшөөрөл олгох, гадаадын иргэн, гэр бүлд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх чиг үүргийг гүйцэтгэдэг, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэгтэй төрийн захиргааны байгууллага тул гэрээний үндсэн дээр үндсэн чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх хэрэгцээ, шаардлага гарахгүй, тэдний чиг үүрэгтэй ажлын давхардал үүсдэггүй болно.	100		
16.		3.	Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх чиглэлээр шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулж, хэлэлцүүлэхийг Засгийн	Гадаадын иргэн, харьяатын газар нь үндэсний аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэгтэй төрийн захиргааны байгууллага тул гэрээний үндсэн дээр үндсэн чиг үүргийг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх хэрэгцээ, шаардлага, ажлын давхардал үүсдэггүй.	100		3.10.2

1	2	3	4	5	6	7	8
			газрын гишүүдэд даалгасугай.				
17.	Монгол Улсын иргэдийн Бүгд Найрамдах Солонгос Улсад зорчих нөхцөлийг хөнгөвчлөх чиглэлээр авах арга хэмжээний тухай 2023-05-03 Дугаар 2023_166	1.	Монгол Улсын иргэдийн Бүгд Найрамдах Солонгос Улсад зорчих нөхцөлийг хөнгөвчлөх чиглэлээр Бүгд Найрамдах Солонгос Улсын Хууль зүйн яамтай хэлэлцээ хийх, хамтран ажиллах төлөвлөгөө гарган ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг нарт тус тус даалгасугай.	Монгол Улсын иргэдийн Бүгд Найрамдах Солонгос Улсад зорчих нөхцөлийг хөнгөвчлөх чиглэлээр Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/97 дугаар тушаалаар байгуулсан БНСУ-ын Хууль зүйн яамтай хэлэлцээ хийх үүрэг бүхий “Ажлын хэсэг”-ийн бүрэлдэхүүнд байгууллагын дарга ажиллаж, 2024 онд 2 удаа, энэ онд 1 удаагийн хэлэлцээр, албан уулзалтад оролцсон. Арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улсын Цагаачлалын бодлого болон хууль бус цагаачдын тоог бууруулах тэдгээрийг хууль ёсны дагуу цагаачлуулж, гадаадын иргэдэд ээлтэй нийгмийг бүтээх нь нийгэм, эдийн засгийн хөгжилд хэрхэн хувь нэмэр оруулж болох талаар төлөвлөгөөний дагуу сурвалжилга бэлтгэн иргэдийн харилцан таатай зорчих нөхцөл байдлыг сайжруулахад чиглэсэн соён гэгээрүүлэх нэвтрүүлгийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээх ажлыг зохион байгууллаа. - 17 мянган монголчууд БНСУ-д визийн зөрчилтэй амьдарч байна. Визийн зөрчилд орвол тус улсын нийгмийн үйлчилгээ авах боломжгүй. By Eagle News Facebook - Оюутнууд визний зөрчилд орохгүй байх дээрээ маш их анхаарах шаардлагатай. Визийн хөнгөлөлтийн асуудал тавихад Солонгосын тал визийн зөрчилтэй иргэдийнхээ... By Eagle News Facebook - БНСУ-д зорчихыг хүсэгчид виз мэдүүлэх, нэвтрэх хуудас бөглөх, зорилго хаяг төлөвлөгөөгөө үнэн зөв тайлбарлах нь чухал. By Eagle News Facebook - БНСУ-ын визийн мэдүүлэгт бичсэн хаягаа нэвтрэх хуудсанд зөрүүгүй бичих, аяллын зорилгоо тодорхой мэдээлэхгүйгээс иргэдийг хил дээрээс буцааж байна. By Eagle News Facebook Түүнчлэн Бүгд Найрамдах Солонгос Улсын Шилжилт хөдөлгөөний судалгаа, сургалтын төвөөс тус улсад	100		

1	2	3	4	5	6	7	8
				оршин суугаа монгол иргэдийн талаар хийсэн статистик судалгааны дүнг 04 дүгээр сарын 15-ны өдөр танилцуулж, уг судалгаанд үндэслэн иргэдийн зорчих зорилго, ажил эрхлэлт, оюутны эзлэх хувь зэргийг тодорхойлох, цаашид зорилтот бүлэгт чиглэсэн бодлого, арга хэмжээг төлөвлөх бодит дата суурь бүрдүүлсэн байна.			
18.	Журам батлах тухай 2024-02-28 Дугаар 2024_77	3.	Энэ журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй. (Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журам")	Эдийн засаг хөгжлийн яам, Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй "МОН3936: Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл"-ийн бүрэлдэхүүн хэсэг ЗҮ-03: "Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем"-ийн хөгжүүлэлтийг 2024 оноос эхэлж, журмын дагуу төслийн нэгжээс Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд холбогдох баримт, хүсэлтийг хүргүүлэн зөвшөөрөл, зөвлөмжийг авсан. https://isf.mn/mn/ Түүнчлэн Монгол Улсад оршин суух зөвшөөрөл авсан иргэнд олгох оршин суух үнэмлэх хэвлэх киоск төхөөрөмжийн программ хангамжийн хөгжүүлэлтэд саналыг 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 01/2048 дугаар албан бичгээр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хүргүүлэн зөвлөмж авч, зөвлөмжийг хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100		
19.	Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай 2024-02-28 Дугаар 2024_82	2.	Төрийн албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг олгоход шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. /2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш тайлагнах/ (1."Журам батлах тухай" Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 6 дугаар	Тайлант хугацаанд орон нутагт ажиллаж буй төрийн үйлчилгээний 39 албан хаагчид батлагдсан төсвийн хүрээнд 73.7 сая төгрөгийн орон нутагт ажилласны нэмэгдлийг олгосон. www.shilendans.gov.mn	100		

1	2	3	4	5	6	7	8
			хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”-ыг хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.)				
20.	Цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2024-05-15 Дугаар 2024_215	2.	Төрийн байгууллага өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх, үүнтэй холбогдсон гомдлыг Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан авч, зөрчил гаргасан албан тушаалтанд хуульд заасан үндэслэл, журмын дагуу хариуцлага тооцож байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Байгууллага өөрт байгаа буюу нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байхад анхаарч, иргэдэд чирэгдэл үүсгэхгүйгээр үйл ажиллагааг цахимд шилжүүлэн 31 төрлийн үйлчилгээ үзүүлж байна. Дээрх асуудлаар хүн, хуулийн этгээдээс байгууллагад холбогдуулан Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд тайлант хугацаанд гомдол ирүүлээгүй байна.	100		
21.	Журам батлах тухай “Төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагааг зохицуулах журам” 2024-10-09 Дугаар 2024_120 1	2.	Энэ тогтоолын хавсралтаар баталсан журмыг (Төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагааг зохицуулах журам) үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг холбогдох төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон	Төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагаа 2025 онд байхгүй болно.	-		

1	2	3	4	5	6	7	8
			нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагад тус тус үүрэг болгосугай. (3.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Тагнуулын ерөнхий газар (П.Одонбаатар)-т тус тус даалгасугай)				
22.	Жуулчдын урсгалыг нэмэгдүүлж, дөрвөн улирлын турш жуулчин хүлээн авах зорилтын хүрээнд хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2024-11-27 Дугаар 2024_191_01	2.3.	Аялал жуулчлалын нэгдсэн цаглабрыг боловсруулж, улирлын онцлогийг харгалзан салбарын олон улсын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, урлаг, соёл, спортын зарим арга хэмжээг жил бүрийн 10 дугаар сараас дараа жилийн 4 дүгээр сар хүртэл хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт.	Монгол Улс дахь “Гадаадын иргэний эрх зүйн байдал, тулгамдсан асуудал, шийдэл” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Стратеги судалгааны хүрээлэнтэй хамтран 04 дүгээр сарын 30-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яаманд зохион байгуулж, хуралд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Хил хамгаалах ерөнхий газар, Зорчигчийн мэдээллийн төв, Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын төлөөлөл оролцлоо.	100		
23.	Танилт, нэвтрэлтийн арга, хэрэгсэл батлах тухай 2024-12-18 Дугаар 2024_217	2.2.	Хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхэд танилт, нэвтрэлтийн системийг ашиглахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга нарт болон төрийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай.	Гадаадын иргэн, харьяатын газраас иргэн, хуулийн этгээдэд цахимаар үзүүлж байгаа үйлчилгээний үндсэн бүртгэлийн систем болох “Гадаадын иргэний виз, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан (isf.mn)” системд 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс Танилт нэвтрэлтийн ДАН системийг холбон үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус системийг холбосноос хойш нийт 132594 удаагийн хүсэлтээр 261242 иргэний баримт материалыг хүлээн авч тус тус хянан шийдвэрлэлээ. https://isf.mn/mn/	100		

1	2	3	4	5	6	7	8
24.	Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай 2024-12-20 Дугаар 2024_226	2.2	Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд Агаарын тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга болон нийслэлийн бүх шатны Засаг дарга нарт даалгасугай.	Засгийн газрын тогтоолоор Нийслэлийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллагыг 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийг дуустал хугацаанд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан байгууллагын даргын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Гамшгаас хамгаалах орон тооны бус штаб, бүлэг байгуулах тухай” А/594 дүгээр тушаалыг баталж, “Гамшгийн үед ажиллах төлөвлөгөө”-г шинэчлэн ажлын өдрүүдэд албан хаагчдын 30 хувийг зайнаас ажиллуулах хуваарь гарган ажиллуулсан. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хүрээнд улирлын ханиад томуунаас урьдчилан сэргийлэх зорилгоор албан хаагчдыг нэг удаагийн маск болон амин дэмээр хангаж, Агаарын тухай хуулийн хүрээнд агаарын бохирдол, түгжрэлийг бууруулах зорилгоор хөдөлгөөнт эх үүсвэр болох хувийн тээврийн хэрэгслээс татгалзуулан албан хаагчдыг нэгдсэн автобусаар ажилдаа ирэх, тарахад үйлчилж байна. Бүх нийтээр тэмдэглэх баяр наадмын өдрүүдэд байгууллагын үйл ажиллагаа, харилцаа холбооны хэвийн байдлыг хангах зорилгоор 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/98 дугаар, 2025 оны 07 дугаар сарын 07-ний өдрийн А/313 дугаар “Хариуцлагатай эргүүл, жижүүр томилох тухай” тушаал батлан хэрэгжилтийг хангаж ажиллалаа.	100		
25.	Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс"-ийн Захирагчийн ажлын албаны бүтэц, орон тооны хязгаар батлах тухай	3.3	“Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс”-ийн Захирагчийн ажлын албаны үйл ажиллагааны зардлыг 2025 оны батлагдсан төсөвтөө багтаан, цаашид жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан нарт, чөлөөт	“Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс”-ийн бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэхэд байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд хамтран ажиллах бэлтгэлийг бүрэн хангасан.	100		3.10.7

1	2	3	4	5	6	7	8
	2025-02-12 Дугаар 2025_83		бүсийн бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэхэд холбогдох хууль тогтоомжийн дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгасугай.				
26.	Экспортын орлогыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай 2025-02-19 Дугаар 2025_94	4.4.	Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалт татах зорилгоор гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж болон иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэж ажиллахыг бүх шатны төрийн захиргааны байгууллагад үүрэг болгосугай.	Тайлант хугацаанд байгууллагад холбогдуулан гадаадын хөрөнгө оруулалттай 1 аж ахуйн нэгжээс гомдол ирүүлсэн байна. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас “Бууралстоун” ХХК-аас гаргасан гомдлыг 7/2422 дугаар албан бичгээр уламжилсныг хүлээн авч хуулийн хүрээнд шуурхай шийдвэрлэн 05 сарын 15-ны өдрийн 01/965 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн. https://edoc.mojha.gov.mn/	100		
27.	Олон улсын худалдааны тарифын нөхцөл байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2025-03-12 Дугаар 2025_132	1.	Олон улсад үүсэж байгаа геополитикийн болон худалдааны хурцадмал, тодорхойгүй нөхцөл байдалтай холбогдуулан хүн амд үзүүлэх үйлчилгээний зохицуулалтын уялдааг хангах, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх орчны тогтвортой байдлыг дэмжих зорилгоор төрөөс иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа бүх төрлийн үйлчилгээний төлбөр, хураамжийг 2025 оны төсвийн жилд нэмэгдүүлэхгүй байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн	Засгийн газрын 2021 оны “Улсын тэмдэгтийн хураамж, визийн үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох тухай” 195 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 485 дугаар тогтоолоор тус тус баталсан Монгол Улсын виз, оршин суух зөвшөөрөл олгох, виз, оршин суух зөвшөөрлийн хүсэлтийг хянах, бүртгэх болон консулын үйлчилгээ үзүүлэхэд хураах тэмдэгтийн хураамж, виз, оршин суух зөвшөөрлийн үйлчилгээний хөлсний хэмжээг баримтлан улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэн ажиллаж байна. www.legalinfo.mn	100		

1	2	3	4	5	6	7	8
			дарга нар, зөвлөл, хороо, комиссын дарга нар, бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.				
28.	Агаарын бохирдлыг бууруулах талаар авар зарим арга хэмжээний тухай 2025-03-19 Дугаар 2025_133	2.2.	Энэ тогтоолын хавсралтад заасан байршилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд бөгөөд Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны дарга С.Одонтуяа, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь нарт, төлөвлөгөөний биелэлтийг 2025 оны III улиралд багтаан хангахыг Засгийн газрын гишүүд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт тус тус үүрэг болгосугай.	Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагаанд хамаарахгүй болно.	-		3.10.7
29.	Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын хаалттай бүс байгуулах тухай 2025-03-26 Дугаар 2025_157	1.1	Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэхтэй холбогдуулан улсын хилийн зурваст бүтээн байгуулалтын хаалттай бүс байгуулах асуудлыг шийдвэрлэхийг Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Хууль зүй, дотоод хэргийн	Хилийн Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын төслийн ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд “Таван толгой” төмөр зам ХХК-ын урилгаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас С1 төрлийн визийн зөвшөөрөлтэй 88 иргэнийг ажиллах хүчээр урьж, ногоон гарц болгон тоног төхөөрөмж, ажиллах хүн хүчийг нэвтрүүлэх зорилготойгоор хаалттай бүсийг байгуулсан. Мөн хилийн дундын бүсэд Төмөр замын шонгийн суурийн 114 өрөмдлөгийн нүхэнд шонгийн суурь босгох ажил хийгдэж, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 137 иргэн төслийн хүрээнд ажиллаж байна. https://isf.mn/	100		

1	2	3	4	5	6	7	8
			сайд О.Алтангэрэл, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал), Хил хамгаалах ерөнхий газар (Х.Лхагвасүрэн), Гадаадын иргэн, харьяатын газар (Н.Ууганбаяр), Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Энхбат, "Тавантолгой төмөр зам" ХХК (Б.Дүгэржав)-д даалгасугай.				
30.		2.2	Бүтээн байгуулалтын хаалттай бүс байгуулах асуудлаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын холбогдох байгууллагатай тохиролцох яриа хэлэлцээ хийхийг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал), Хил хамгаалах ерөнхий газар (Х.Лхагвасүрэн), Гадаадын иргэн, харьяатын газар (Н.Ууганбаяр)-т даалгасугай.	Бүтээн байгуулалтын хаалттай бүс байгуулах асуудлаар 07 дугаар сард зохион байгуулагдсан Менежментийн 06 дугаар хуралд Хилийн боомтын захиргааны дарга оролцож, хаалттай бүсэд ажиллах журмын талаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талтай санал солилцсон. Монголын талаас Хятадын талд хүргүүлсэн "Хаалттай бүсэд ажиллах журам"-ын төслийн хариу ирээгүй байна. Хаалттай бүсэд ажиллах хүч болох БНХАУ-ын 166 иргэнийг хилийн боомтоор зохих ангилал, зориулалтын визээр хил нэвтрүүлсэн. https://isf.mn/	100		
31.	Хойд бүсийн хөгжлийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай	1.1.4.	Аялал жуулчлалын дэд бүтцийн хөгжлийг дэмжих зорилгоор Бүгд Найрамдах Солонгос Улс-Хөвсгөл аймгийн Мөрөн сум чиглэлд олон улсын шууд нислэг	Гадаадын иргэн, харьяатын газрын Хөвсгөл аймаг дахь хэлтэс нь Мөрөн нисэх онгоцны буудлын 3 м² 1 өрөөг тохижуулан үйл ажиллагаа явуулж байна. Мөрөн Олон улсын нисэх буудалд "Чонжү-Мөрөн" чиглэлийн олон улсын шууд нислэг MR616, MLM616 дугаар агаарын хөлгүүдээр 2025 оны 07 дугаар сарын	83.3		

1	2	3	4	5	6	7	8
	2025-04-28 Дугаар 2025_204		үйлдэх нөхцөлийг бүрдүүлж, нисэх буудлыг 4С ангиллын шаардлагад нийцүүлэн өргөтгөх, хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр бэлтгэл ажлыг хангаж, шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг 2026 оны улсын төсөвт тусган шийдвэрлүүлэхийг Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Сангийн сайд Б.Жавхлан, Хөвсгөл аймгийн Засаг дарга Л.Төмөрбаатар нарт, жуулчдыг саадгүй нэвтрүүлэх боломжийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэхийг Гадаадын иргэн, харьяатын газар (Н.Ууганбаяр), Хил хамгаалах ерөнхий газар (Ж.Бямбасүрэн), Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал)-т.	29, 08 дугаар сарын 02-ны өдрүүдэд газардаж, эхний нислэгээр 2 улсын 98 гадаадын иргэн, хоёр дахь нислэгээр 1 улсын 94 иргэнийг тус тус хүлээн авч, хяналт тавин ажиллалаа.			
32.	Ажил, амралтын цагийн зохицуулалтын тухай 2025-06-04 Дугаар 2025_279	1.1	Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын 2025 оны 07 дугаар сарын 12, 13-ны өдрүүд нь Бямба, Ням гарагт тохиож байгаатай холбогдуулан 2025 оны 07 дугаар сарын 16, 17-ны өдрийн Лхагва, Пүрэв гарагт ажилтан, албан хаагчдыг амрааж, 2025 онд багтаан нөхөн ажиллуулах зохицуулалт хийхийг Засгийн	Байгууллагын даргын 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн “Албан хаагчдын нөхөн ажиллуулах тухай” А/282 дугаар тушаалаар 07 дугаар сарын 19, 26-ны өдрүүдэд нөхөн ажиллуулах зохицуулалтыг хийлээ.	100		3.10.1

1	2	3	4	5	6	7	8
			газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад даалгасугай.				
33.	Аймаг, орон нутгийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-07-02 Дугаар 2025_11	1.5	Салбарын хэмжээнд гаргасан бодлого, шийдвэрийн биелэлт, үр дүнтэй орон нутагт биечлэн танилцаж, хэрэгжилтийг зохион байгуулах, тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүдэд.	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хүрээнд хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн албан хаагчдад сургалт зохион байгуулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороотой мэдээлэл солилцох, уялдаа холбоо, зохицуулалтыг хангах, тайлагнах чиг үүрэг бүхий холбогдох албан хаагчдыг арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр хангах зорилгоор удирдамжийг байгууллагын даргын 03 дугаар сарын 11-ний өдрийн А/118 дугаар тушаалаар баталж, удирдамжийн дагуу 03 дугаар сарын 31-ний өдөр Агаарын замын боомт хариуцсан газарт, 04 дүгээр сарын 08-аас 10-ны өдрүүдэд Дорноговь аймаг дахь газарт ажилласан. Арга хэмжээний хүрээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилт, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, албаны чиг үүргээ хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлын талаар хамтарсан уулзалт зохион байгуулж, аргазүйн зөвлөгөөгөөр хангасан. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд 07 дугаар сарын 09-ний өдөр оруулсан өөрчлөлттэй холбогдуулан тээвэр шатахууны зардлыг багасгаж, дотоод албан томилолтын зардалд төсөв батлагдаагүй тул орон нутагт биечлэн ажиллах боломж хязгаарлагдмал байна.	100		3.10.2
34.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй	3	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх арга хэмжээний хэрэгжилтийг хангах хүрээнд бүх талын дэмжлэг үзүүлж, хамтран	“Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Дэд зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 10-	100		

1	2	3	4	5	6	7	8
	тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-07-23 Дугаар 2025_29		ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	ны өдрийн 02 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар шинэчлэн баталсан. “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Дэд зөвлөл”-ийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд манай байгууллагын чиг үүрэгтэй холбоотой тухайлсан ажил, арга хэмжээ тусгагдаагүй бөгөөд төлөвлөгөөний 4.5-д заасан сургалтыг Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газар болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албатай хамтран энэ оны 03 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулж, танхимаар 30, цахимаар 107, нийт 137 албан хаагчийг хамруулсан. Дэд зөвлөлийн хуралдаанд 03 дугаар сарын 31, 06 дугаар сарын 24, 08 дугаар сарын 26-ны өдөр тус тус, ҮАБЗ-ийн Ажлын алба болон ГХУСАЗЗ-ийн Ажлын албатай хамтран хуралдсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хороо”-ны өргөтгөсөн хуралдаанд 05 дугаар сарын 14-ний өдөр Зөрчил шалган шийдвэрлэх газрын дарга тус тус оролцлоо. Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, Шүүх шинжилгээний ерөнхий газартай хамтран энэ оны 11 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгуулсан “Narkotic workshop 2025” сэдэвт сургалтад 2 албан хаагч хамрагдсан. “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Дэд зөвлөл”-ийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 06 дугаар сарын 13-ны өдрийн 05/1148 дугаар албан бичгээр Цагдаагийн ерөнхий газарт, мөн өдрийн 05/1149 дүгээр албан бичгээр Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд тус тус хүргүүлж ажиллав.			
Хэсгийн дундаж: 99 хувь							
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл							

1	2	3	4	5	6	7	8
35.	2022 оны 5 дугаар сарын 4-ний өдөр 27 дугаар тэмдэглэл 2022-05-04 Дугаар 2022_27	XYIII.2 .7.	Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх, бэлтгэл хангах арга хэмжээ авах, үйл ажиллагааг тусгайлан зохицуулсан хөтөлбөр боловсруулж батлуулан ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт;	“Монголд зочлох жил”-ийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн А/314 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус байгууллагаас Виз, зөвшөөрлийн газрын дарга ажиллаж, хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх, бэлтгэл хангах арга хэмжээ авах, үйл ажиллагааг тусгайлан зохицуулсан хөтөлбөрийн дагуу Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн “Журам батлах тухай” 142 дугаар тогтоолоор хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагааг тусгайлан зохицуулсан "Хил орчмын нутаг дэвсгэрийн аялал жуулчлалын үйл ажиллагааг зохион байгуулах, аюулгүй байдлыг хангах журам"-ыг баталсан. https://legalinfo.mn/mn	100		
36.	2023 оны 2 дугаар сарын 20-ны өдөр 9 дүгээр тэмдэглэл 2023-02-20 Дугаар 2023_9	I.2.5.	Иргэдийн зорчих нөхцөлийг хөнгөвчлөх талаар БНСУ-ын холбогдох байгууллагатай хэлэлцээ хийх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулж, энэ хүрээнд дараах асуудлыг хэлэлцэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт: - Монгол Улсын Засгийн газар болон БНСУ-ын Засгийн газар хооронд байгуулсан Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрт холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах замаар харилцан нийгмийн даатгалаас чөлөөлөх хугацааг нэмэгдүүлэх, төлөгдсөн нийгмийн даатгалын буцаан олголтод хамаарах визийн ангилал хүрээг нэмэгдүүлэх; - БНСУ-д эмчилгээ хийлгэж буй иргэдийг дэмжих	Монгол Улсын иргэдийн Бүгд Найрамдах Солонгос Улсад зорчих нөхцөлийг хөнгөвчлөх чиглэлээр Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/97 дугаар тушаалаар байгуулсан БНСУ-ын Хууль зүйн яамтай хэлэлцээ хийх үүрэг бүхий “Ажлын хэсэг”-ийн бүрэлдэхүүнд байгууллагын дарга ажиллаж байна. Байгууллагын дарга БНСУ-ын Сөүл хотын Цагаачлалын албаны даргатай 04 дүгээр сарын 16-ны өдөр албан уулзалт хийж, иргэд хоорондын харилцаа, хамтын ажиллагаа өргөжсөнөөр эдийн засаг, соёл, боловсрол болон аялал жуулчлалын салбарт эерэг нөлөө үзүүлэн “стратегийн түншлэл”-ийн харилцааг бэхжүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байгааг онцлоод тус улсад оршин сууж буй монгол иргэдийг хууль ёсоор оршин суух, аливаа зөрчил, гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх тал дээр анхаарал хандуулахыг хүсэв. Түүнчлэн уулзалтаар БНСУ-д оршин сууж буй монгол иргэдийн дийлэнх хувийг их, дээд сургуульд суралцаж буй оюутнууд эзэлж байгаатай холбогдуулан оршин сууж буй гадаадын иргэний хүүхэд эцэг, эхийнхээ оршин суух зөвшөөрөлтэй эсэхээс үл хамааран ерөнхий боловсролын сургуульд суралцах боломжийг олгож хууль бусаар оршин сууж буй эцэг, эх нь зохих	98.5		Тогтоолтой давхардсан

1	2	3	4	5	6	7	8
			зорилгоор тус улсын эмнэлгүүдийн төлбөрийн хөнгөлөлтийг эдлүүлэх болон эрүүл мэндийн даатгалд хамрагдах; - Хөдөлмөрийн гэрээгээр БНСУ-д ажиллаж буй монгол иргэдийн эцэг, эх, үр хүүхэд, гэр бүлийн зүгээс тус улсад зорчих виз хүсэхэд тодорхой хөнгөлөлт эдлүүлэх.	ангиллын оршин суух зөвшөөрлийг мэдүүлэх боломжийг бүрдүүлж эхэлсэн талаар мэдэгдсэн. БНСУ-ын Сөүл хотноо 12 дугаар сарын 17-ны зохион байгуулагдах Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын Гадаад харилцааны яамдын консулын XII зөвлөлдөх уулзалттай холбогдуулан уулзалтад тусгах саналыг Гадаад харилцааны яаманд цахим шуудангаар хүргүүлээд байна. Саналд иргэдийн визийн хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэх, виз мэдүүлэхэд гадаад паспортыг эх хувиар нь авдагийг хасах, эмчилгээний зорилгоор зорчих монгол иргэд болон тэдний асран хамгаалагчийг тодорхой хугацаанд визийн шаардлагаас чөлөөлүүлэх, хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй монгол иргэдийн эцэг эх, үр хүүхэд, гэр бүлийн гишүүдийн виз хүсэх нөхцөлийг хөнгөвчлүүлэх, виз олгохоос татгалзсан тохиолдолд дахин виз мэдүүлэх боломжит хугацааг богиносгох, хил дээрээс визийн зорилгодоо нийцээгүй байхаас бусад тохиолдолд буцаагдаж буй асуудлыг уян хатан шийдвэрлэх зэрэг асуудлуудыг тусгасан.			
37.	2023 оны 3 дугаар сарын 29-ний өдөр 14 дүгээр тэмдэглэл 2023-03-29 Дугаар 2023_14	XVIII.7.3	XVIII.7.3. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагын ажилтнуудтай 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдөр хийсэн уулзалтын талаар Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав: 3.Олон улсын байгууллагын техник туслалцааны төслийн хүрээнд гадаад улсад	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрөөр Наньжины их сургуульд мэргэжил дээшлүүлэхээр бакалаврын хөтөлбөрт олон улсын улс төр судлал мэргэжлээр суралцаж төгссөн 1 албан хаагчийг байгууллагын даргын 2023 оны Б/200 тушаалаар ажлын байранд нь эргүүлэн томилсон.	100		

1	2	3	4	5	6	7	8
			магистр, доктор болон ахисан түвшний сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдыг төгсмөгц, ажлын байранд нь эргүүлэн томилж ажиллуулах арга хэмжээ авч байхыг яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга нарт;				
38.		XVIII.7 .4.	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагын ажилтнуудтай 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдөр хийсэн уулзалтын талаар Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав: Олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлэх төслийн хүрээнд төрийн албан хаагчийг мэргэшүүлэх зорилгоор гадаад улсад туршлага судлах сургалт, аялалд хамруулах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд;	Тайлант хугацаанд АНУ, БНЭУ, БНСУ, БНХАУ, Тайвань, Филиппин, Швейцар, Унгар улсуудад зохион байгуулагдсан 4 удаагийн сургалт, 6 удаагийн олон улсын хурал, 4 удаагийн уулзалтад нийт 62 албан хаагчийг хамруулсан.	100		
39.	2023 оны 5 дугаар сарын 03-ны өдөр 19 дүгээр тэмдэглэл 2023-05-03	XVIII.8 .3.	Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, байнгын ажиллагаатай хилийн боомтод төрийн үйлчилгээний цэгийг нээхэд	Сэлэнгэ аймаг дахь Сүхбаатар төмөр замын боомтын төрийн нэг цэгийн үйлчилгээний цогцолбор ашиглалтад орсноор Гадаадын иргэн, харьяатын газрын Хойд бүс дэх газар нь 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс тус цогцолборт үйл ажиллагаагаа эрхэлж байна.	100		

1	2	3	4	5	6	7	8
	Дугаар 2023_19		бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт.	Мөн Хөвсгөл аймаг дахь хэлтэс нь Мөрөн нисэх онгоцны буудлын 3 м² нэг өрөөг тохижуулан Мөрөн Олон улсын нисэх буудалд "Чонжү-Мөрөн" чиглэлийн олон улсын шууд нислэгийг хүлээн авч байна. Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газруудын нэг цэгийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх зорилгоор Гадаад харилцааны яамнаас 02 дугаар сарын 03-ны өдөр ирүүлсэн "Жагсаалт"-ын дагуу дипломат төлөөлөгчийн газруудад визийн зөвшөөрлийн жагсаалтыг харах боломжийг ханган тус байгууллагаас "Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (ISF)" системд хандах эрх нээж өгсөн.			
40.	2023 оны 5 дугаар сарын 17-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл 2023-05-17 Дугаар 2023_21	XVIII.2 .3	Монгол Улсын хөгжлийн бодлого, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хүний хөгжил, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг үр нөлөөтэй байхад чиглүүлэн бодитой, үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	Монгол Улсын хөгжлийн бодлого, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хүний хөгжил, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг үр нөлөөтэй байхад чиглүүлэн ажиллаж, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээгээр 2025 онд Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт 100 хувь, "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн хагас жилийн хэрэгжилт 100 хувь, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 93.3 хувь, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн гуравдугаар улирлын биелэлт 97.9 хувь үнэлэгдсэн. https://immigration.gov.mn/	100		
41.	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны 13 дугаар тэмдэглэл 2024-04-03 Дугаар 2024_13	22.6.1	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулах, эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төсөл,	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд Гадаадын иргэн, харьяатын газрын Баруун бүс дэх газрын гадна шугам сүлжээний /Ховд, Жаргалант сум/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт шалгарсан "Элбэггүн ХХК"-тай гэрээ байгуулж, гэрээт ажлыг 100 хувь гүйцэтгэж улсын комисс хүлээн авсан. 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд 5 төсөл арга хэмжээний шалгаруулалтыг tender.gov.mn цахим хуудсаар нээлттэй зарлаж, байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 100 хувьтай хэрэгжсэн.	100		3.10.1

1	2	3	4	5	6	7	8
			арга хэмжээний нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийн талаар мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу тус тус авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт;(.Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн 2024 оны 1 дүгээр улирлын явц, гүйцэтгэлийн талаар)	Баруун бүс дэх газар нь түрээсийн байранд үйл ажиллагаа эрхэлж байсан тул тус төсөл арга хэмжээг хэрэгжүүлснээр гарах нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийн талаарх мэдээллийг харьяалах нутаг дэвсгэртээ сурталчлан таниулж, гадаадын иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй, тасралтгүй хүргэн албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулж, аюулгүй байдлыг хангаж ажилласан. https://www.tender.gov.mn/mn			
42.	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэл 2024-06-06 Дугаар 2024_22	37.4.9.	Нийслэл Улаанбаатар хотын агаарын чанарын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллага болон төрийн өмчит үйлдвэрийн үйлдвэрийн газруудын уурын зуухнуудад технологийн өөрчлөлт хийж, түүхий нүүрсний хэрэглээг бүрэн зогсоох зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг нарт;	Нийслэл Улаанбаатар хотын агаарын чанарын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа Гадаадын иргэн, харьяатын газар нь төвийн төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон тул түүхий нүүрс, ашигладаггүй болно.	100		3.10.1
43.	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны	39.29.12.3.	Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага кибер аюулгүй байдлыг хангах чиг үүргээ тодорхой албан тушаалтанд хариуцуулж, үйл ажиллагааны болон кибер аюулгүй байдлыг хангахад шаардагдах зардлыг жил	Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага кибер аюулгүй байдлыг хангах хүрээнд Мэдээллийн технологийн хэлтсийн кибер аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтний сул орон тоонд тус нэгжийн өгөгдлийн сан хариуцсан мэргэжилтнийг байгууллагын даргын 03 дугаар 07-ны өдрийн Б/52 дугаар тушаалаар Төрийн албаны тухай хууль тогтоомжийн дагуу шилжүүлэн ажиллуулсан.	100		3.10.1

1	2	3	4	5	6	7	8
	39 дүгээр тэмдэглэл 2024-11-13 Дугаар 2024_39		бүрийн төсвийн төсөлд тусгаж байхыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт;	Кибер аюулгүй байдлыг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсвийн төсөлд тусган арга хэмжээний хүрээнд 2024 оны 12 дугаар сард 19,9 сая төгрөгийн өртөгтэй хамгаалалтын лиценз, 19,9 сая төгрөгийн өртөг бүхий сүлжээний төхөөрөмжийг тус тус худалдан авч, ашиглаж байна. 2026 оны төсөвт 708,1 сая төгрөгийг программ хангамжийн лиценз худалдан авахаар тусгасан.			
44.	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдааны 41 дүгээр тэмдэглэл 2024-11-27 Дугаар 2024_41	41.13. 2.1.	Засгийн газрын 2022 оны 178 дугаар тогтоолоор Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэдийг Монгол Улсын визийн шаардлагаас чөлөөлсөн хугацааг сунгах асуудлыг судалж, зохих журмын дагуу шаардлагатай арга хэмжээ авахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл нарт;	2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 235 дугаар тогтоолоор 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 178 дугаар тогтоолын 1 дэх заалтад өөрчлөлт оруулж, Монгол Улсад 90 хүртэл хоногийн хугацаагаар жуулчлах Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэдийг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл Монгол Улсын визийн шаардлагаас чөлөөлсөн.	100		3.10.1
45.		41.13. 2.2.	Жуулчдад цахим виз олгох журам, шаардлагыг олон улсад сурталчлан таниулах, цахим визийн системд сайжруулалт хийж, бүлэг жуулчдад (8 буюу түүнээс дээш тооны) виз олгох хувилбарыг нэвтрүүлэх арга хэмжээ авахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл нарт;	“Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан систем”-д нэмэлт хөгжүүлэлтээр хилийн боомтод бүлэг жуулчинд виз олгох үйлчилгээг нэвтрүүлэх, төлбөрийн системийг сайжруулах асуудлаар уг системийг хөгжүүлэгч болох Аствишн ХХК-тай 01 дүгээр сарын 30-ны өдөр уулзалт хийж, хөгжүүллээ. Түүнчлэн цахим визийн системд нэмэлт сайжруулалт хийх CR-25-MFA-01 хүсэлтийн дугаартай 19,719,700 төгрөгийн гэрээг гүйцэтгэгч байгууллага Интерактив ХХК-тай байгуулан шинэчлэлийг 03 дугаар сарын 24-ний өдрөөс үйл ажиллагаанд нэвтрүүллээ. Засгийн газар хоорондын, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, олон улсын байгууллагын шугамаар ирэх гадаадын иргэнд олгох АЗ ангиллын 10 хоног, ажил хэргийн шугамаар ирэх гадаадын иргэнд олгох К1 ангиллын 10 хоногийн визийн ангилалд системийг хөгжүүлэн 12 дугаар сарын 09-ний өдрөөс үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Жуулчдад цахим виз	100		

1	2	3	4	5	6	7	8
				олгох журам, шаардлага, шинээр нэвтрүүлсэн үйлчилгээнүүдийг 5 хэл дээрх байгууллагын цахим хуудаст нийтлэн олон улсад сурталчлан таниулж байна. https://immigration.gov.mn/mn/articles/524/			
46.		41.13.2.3.	Хил орчмын аялал жуулчлалын чиглэлд автомашинтай аялах хүсэлтэй жуулчдыг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ болон дотоодын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд чөлөөтэй зорчих боломжийг хангах арга хэмжээ авч ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал)-т;	Хил орчмын аялал жуулчлалын чиглэлд автомашинтай аялах хүсэлтэй жуулчдыг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ болон дотоодын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд чөлөөтэй зорчих боломжийг хангах арга хэмжээний хүрээнд хилээр саадгүй нэвтрүүлэхийн тулд тус байгууллагаас жуулчлах зорилгоор хил нэвтрэх гадаадын иргэнд цахим визийг 48 цагийн дотор хянан шийдвэрлэж байна. Хил орчмын нутаг дэвсгэрт автомашинтай аялах жуулчдыг чөлөөтэй зорчуулах боломж нь авто машин барих эрхийн үнэмлэх бөгөөд энэ нь Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарна.	100		3.10.7
47.	Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 44 дүгээр тэмдэглэл 2025-01-18 Дугаар 2024_44	44.22.1.11	Агаар, орчны бохирдлын талаар холбогдох төрийн байгууллагуудын тоон болон чанарын үзүүлэлт бүхий мэдээллийг нэгтгэсэн мэдээллийн сан, нэгдсэн дашбоард үүсгэхийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд, холбогдох мэдээллийн үнэн зөв, бодит байдалд хяналт тавьж, тухай бүр шинэчилж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд	Гадаадын иргэн, харьяатын газар нь төвийн төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон тул түүхий нүүрс, усан халаалтын зуух ашигладаггүй болно.	100		3.10.7
48.	Монгол Улсын Засгийн	5.24.1 0.1	Бүсийн хамтын ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх	Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс 05 дугаар сарын 01, 02-ны өдрүүдэд Хэнтий аймагт зохион	100		3.10.1

1	2	3	4	5	6	7	8
	газрын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны 5 дугаар тэмдэглэл 2025-01-22 Дугаар 2025_05		хөдөлгөөн өрнүүлэх хүрээнд олон талт арга хэмжээ зохион байгуулж, хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.(Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан зохион байгуулах төлөвлөгөөний талаар)	байгуулсан “Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал” Зүүн бүсийн зөвлөгөөнд 1 албан хаагч, мөн сарын 28, 29-ний өдрүүдэд Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран Улаанбаатар хотноо зохион байгуулсан уг зөвлөгөөнд 4 албан хаагч тус тус оролцлоо. Зөвлөгөөнөөр хэлэлцэгдсэн анхаарах асуудлын хүрээнд олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлэн 01-02/48 дугаар удирдамжийн дагуу 10 дугаар сарын 15-20-ны өдрүүдэд хилийн боомт, орон нутаг дахь 6 газар, 1 хэлтсийн “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системийн хөтлөлтөд нэгж тус бүрийн ажлын байр, албан хаагчийн үндсэн мэдээлэл (12 төрөл), баталгаажилтад хяналт шалгалт хийж, байгууллагын даргын 10 дугаар сарын 24-ний өдрийн 01/1907 дугаар албан бичгээр зөвлөмж, чиглэл хүргүүлсэн. Шинээр томилогдсон болон шилжүүлэн ажиллуулсан, албан тушаал шилжсэн, ажлаас чөлөөлөгдсөн, албан үүрэг түр орлон гүйцэтгүүлэх 46, албан тушаалын цалин шинэчлэгдсэн 105, мэргэшлийн зэргийг шинээр болон ахиулан олгосон 47, нийт давхардсан тоогоор 198 албан хаагчийн мэдээллийг “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд шинэчиллээ. Мөн арга хэмжээний хүрээнд төрийн албан хаагч төрд байгаа өөрийн мэдээлэлтэй танилцаж, шинэчлэн баталгаажуулах зорилгоор байгууллагын хэмжээнд 306 албан хаагчийн хувийн мэдээллийг бүрэн засварлан баталгаажуулсан.			
49.	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэл	10.19.4.1	Тогтоол, шийдвэр батлах эрх зүйн үндэслэлд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан зорилго, зорилт, арга хэмжээний дугаар, өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлж дуусах хугацааг тодорхой зааж байхыг	Байгууллагын даргын шийдвэрийг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн зорилго, зорилт, арга хэмжээтэй уялдуулан хэрэгжүүлж, биелэлт, үр дүнг тооцон ажиллаж байна. Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоотой зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар ХЗДХЯ-аас хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр 88.7 хувь үнэлэгдсэн.	100		3.10.1

1	2	3	4	5	6	7	8
	2025-02-26 Дугаар 2025_10		Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:(19.4.Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн талаар)				
50.	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-04-09 Дугаар 2025_16	16.20. 1.2	Зайлшгүй шаардлагатайгаас бусад үйл ажиллагааг хуралдаантай давхцуулан зохион байгуулах, албан хаагчдыг томилолтоор ажиллуулахгүй байхад анхаарч, нэгдсэн журмаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Архангай аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмид, Баянхонгор аймгийн Засаг дарга Д.Мөнхсайхан, Өвөрхангай аймгийн Засаг дарга О.Пүрэвдорж нарт;	УИХ, Засгийн газрын хуралдаантай давхцуулан үйл ажиллагаа зохион байгуулаагүй, Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймгийн төлөөллийг албан томилолтоор ажиллуулаагүй болно.	100		3.10.7
51.	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 19 дүгээр хуралдааны тэмдэглэл 2025-04-23 Дугаар 2025_19	19.24. 1.1	Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын барилга угсралтын ажлын нээлтийн үйл ажиллагааны талаарх саналыг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талд дипломат шугамаар мэдэгдэж, нээлтийн үйл ажиллагааг өндөр түвшинд зохион байгуулахыг Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Гадаад	Хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлын нээлтийн ёслолыг 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр өндөр түвшинд зохион байгууллаа. Ёслолын арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын ӨМӨЗО-ны Намын хорооны нарийн бичгийн дарга, “Чайна Энержи” группийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Хятадын төмөр замын барилгын корпораци (CRCC)-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон хоёр улсын Засгийн газар, улс төр, төрийн өндөр түвшний албаныхан, холбогдох яам, агентлаг,	100		3.10.1

1	2	3	4	5	6	7	8
			харилцааны сайд Б.Батцэцэг, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Хил хамгаалах ерөнхий газар (Ж.Бямбасүрэн), Гадаадын иргэн, харьяатын газар (Н.Ууганбаяр), Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал), Төрийн тусгай хамгаалалтын газар (Л.Алтангэрэл)-т тус тус даалгав. (Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын явцын талаар)	байгууллагуудын удирдлага, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллүүд оролцсон байна. Төслийн хүрээнд үндсэн 7 багц ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд: - Төмөр замын дээд ба доод бүтцийн ажил - Гүүрэн байгууламж - Эрчим хүчний дэд бүтэц - Барилга байгууламжууд - Дохиолол, холбооны систем - Авто зам, дэд бүтэц - Гааль, хилийн хяналтын цогцолбор зэрэг барилга байгууламж барих.			
52.	2025 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 23 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-05-12 Дугаар 2025_23	23.2.2.2	Говийн бүсийн байгаль, газар зүйн онцлогт түшиглэсэн хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд аялал жуулчлалын маршрутыг батлах болон тухайн маршрутаар зорчих гадаадын иргэдэд Монгол Улсын хилээр нэвтрэх үнэмлэх олгох асуудлыг холбогдох олон улсын гэрээ, хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх боломжийн талаар судалж, танилцуулахыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл нарт даалгав.”(2.2.“Говийн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх	Гадаад харилцааны яамнаас ирүүлсэн 07 дугаар сарын 03-ны өдрийн 01/3290 дүгээр албан бичигт дурдсанаар БНХАУ-ын Соёл, аялал жуулчлалын яам, Гадаад хэргийн яам, Нийгмийг аюулаас хамгаалах яам, Гаалийн ерөнхий газраас хамтран “Хил орчмын аялал жуулчлалыг зохицуулах журам”-ыг шинэчлэн баталж, 06 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэхээр заасан ба түүний хавсралтаар баталсан “Хил орчимд аялах хятад иргэдийн бүлэг жуулчдын нэрсийн жагсаалт”-ын загварыг хүргүүлэн энэхүү загвараар бүлэг жуулчид хил орчимд аялах бэлтгэл хангадсаныг мэдэгджээ. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.7-д “Визийн загварыг гадаад харилцааны болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” Монгол Улсын виз олгох журмын 6.7-д “Хил орчмын аялал жуулчлалаар ирэх бүлэг жуулчинд олгох “К3” ангиллын визийг ахлагчийн паспорт дээр, дагалдан зорчих гишүүдийн визийг жагсаалтаар буюу хавсралт хуудсаар олгож болно” гэж зохицуулсан тул жагсаалт хэлбэрээр олгох К3 ангиллын визийн загвартай	90		

1	2	3	4	5	6	7	8
			зарим арга хэмжээний тухай")	холбогдох саналыг 07 дугаар сарын 22-ны өдрийн 01/1339 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээ. Загвар батлагдсан тохиолдолд "КЗ" ангиллын виз гэж үзэх боломжтой.			
53.	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 24 дүгээр хуралдааны тэмдэглэлд 2025-05-21 Дугаар 2025_24	24.35.7.1.2	Өөрийн эрхлэх асуудлын хүрээний орон нутаг дахь удирдлагын босоо тогтолцоотой нэгжийн үйл ажиллагааны бүтэц, чиг үүрэгт шинжилгээ, тооцоо судалгаа хийж, харьяа аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, иргэдийн саналыг үндэслэн байгууллагын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт оруулах өөрчлөлтийн санал боловсруулж, танилцуулахыг Засгийн газрын гишүүдэд;	Засгийн газрын 2025 оны "Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Засгийн газрын агентлагийн орон тооны дээд хязгаар"-т багтаан байгууллагын зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт зарим нэгжийн чиг үүрэг, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэлд чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах зорилгоор үндсэн чиг үүргийн бүтцийн нэгжийн орон тоог нэмэгдүүлэх, нэгж хооронд зарим чиг үүргийг шилжүүлэн иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, Монгол Улсын хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөний хүрээнд төсвийн зардлыг хязгаарлах, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбоотой өөрчлөлтийн саналыг байгууллагын даргын 09 дүгээр сарын 15-ны өдрийн 01/1656 албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдад уламжилсан.	100		дууссан
54.	Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 4 дүгээр хуралдааны тэмдэглэл 2025-07-02 Дугаар 2025_4	1.1	Эрхэлсэн чиг үүрэг, харьяа салбарын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа Засгийн газрын агентлаг, төв, нэгж, улсын үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн чиг үүрэг, үйл ажиллагааны үр ашиг, үндэслэл, хэрэгцээ, шаардлагад дүн шинжилгээ хийж, нэгтгэх, нийлүүлэх, татан буулгах замаар өөрчлөн зохион байгуулах, чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, бүтэц, орон тоог оновчтой тогтоох, төрийн зарим чиг үүргийг	Засгийн газрын 2025 оны "Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 52 дугаар тогтоолын 4.1, 4.2, 4.3, 4.4, 4.6-д заасан чиглэл байгууллагад хангагдсан, харин 4.7-д "үндсэн чиг үүрэг хариуцсан нэгжийн орон тоог нийтлэг чиг үүрэг хариуцсан нэгжийн орон тооноос илүү байхаар тогтоох" чиглэлд нийцүүлэх шаардлага бий. Албан тушаалын төрлөөр нийт албан хаагчдын 20 буюу 6.3 хувийг удирдах албан тушаалтан эзэлж байгаа нь Монгол Улсын Төрийн албаны 2024 оны төрийн тусгай албан хаагчийн нэгдсэн тоо бүртгэлийн дүн, улсын дундажтай харьцуулахад удирдах албан тушаалтны эзлэх хувь 2.7, төрийн жинхэнэ албаны дүнгээр 4 хувиар тус тус бага байгааг судалж, 09 дүгээр сарын 15-ны өдрийн 01/1656 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлсэн.	100		3.10.1

1	2	3	4	5	6	7	8
			мэргэжлийн холбоодод шилжүүлэн гүйцэтгүүлэх саналыг холбогдох шийдвэрийн төслийн хамт боловсруулж, 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах;				
55.		1.2	Засгийн газрын агентлагийн үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг боловсруулахад зохион байгуулалтын бүтцийн нэгж, ажилтны чиг үүрэг, хариуцах ажил нь яамны зохион байгуулалтын бүтцийн нэгж, албан хаагчийн болон тухайн агентлагийн харьяа төв, орон нутгийн байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, компани, гэрээний үндсэн дээр төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын хариуцсан чиг үүрэг, ажилтай давхардахгүй байх чиглэл баримтлах;	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Харьяатын тухай хууль, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн үзэл баримтлалд заасан төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллагын хувьд гэрээгээр төрийн бус байгууллагаар ажил гүйцэтгүүлэх боломжгүй тул чиг үүргийн давхардал байхгүй болно.	100		3.10.1
56.		1.3	Засгийн газрын агентлагийн бүтцийн нэгжийн оноосон нэр нь яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн нэртэй давхардахгүй байх, хуульд өөрөөр заагаагүй бол дэд, орлогч даргагүй байх, үндсэн чиг үүрэгт хамааралгүй хэлтэс газар дотор байгуулахгүй байх, хэлтэс нь дотроо тасаг,	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны А/129 дүгээр тушаалаар батлуулан мөрдөж байгаа одоогийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн нэршилд харьцуулалт хийхэд салбарын яамны 7 газар, 6 хэлтсийн оноосон нэр болон чиг үүрэгтэй байгууллагын зохион байгуулалтын нэгжийн нэрийн болон чиг үүргийн давхардал үүсээгүй болохыг судалж, 09 дүгээр сарын 15-ны өдрийн 01/1656 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлээ. Байгууллагад дэд даргын орон тоо байхгүй болно.	100		3.10.1

1	2	3	4	5	6	7	8
			албагүй байхаар тогтоох чиглэл баримтлах;				
57.		1.4	Засгийн газрын агентлагийн орон тооны дээд хязгаар тогтоох саналыг Монгол Улсын хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөнд заасан орон тоо бууруулах чиглэл, төсвийн зардлыг хязгаарлах, хэмнэх зорилгод нийцүүлэн боловсруулах.	2026 оны төсвийн төслийн саналыг 316 орон тоотойгоор, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд зардлын тооцоог боловсруулан дээд шатны байгууллагад хүргүүлсэн. https://shilendans.gov.mn/	100		3.10.1
58.	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 09 дүгээр хуралдааны тэмдэглэл 2025-07-23 Дугаар 2025_09	5.1.5	Төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй, шуурхай үзүүлэх, цахимжуулж ажиллахыг яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт, алдаа, зөрчил гаргасан албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцож ажиллахыг Засгийн газрын гишүүдэд, хяналт тавьж, салбар дундын уялдаа зохицуулалтыг хангаж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогтод.	Төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй, шуурхай үзүүлэх зорилгоор Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамтай 2025 онд Ц/ХУР-2025/436 дугаартай “Үндсэн систем (ХУР)-ийг ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээ”, Ц/ХУР-2025/436-97 дугаартай “Үндсэн систем (ХУР)-ийг ашиглан үйлчилгээ үзүүлэх нэмэлт гэрээ”, Ц/ХУР-2025/436-102 дугаартай “Үндсэн систем (ХУР)-ийг ашиглан үйлчилгээ үзүүлэх нэмэлт гэрээ”, Ц/ХУР-2025/436-144 дугаартай “Үндсэн систем (ХУР)-ийг ашиглан үйлчилгээ үзүүлэх нэмэлт гэрээ”-г тус тус байгуулан нийт 6 байгууллагын 32 төрлийн сервисээр мэдээлэл авч, 25 байгууллагад 13 сервисээр мэдээлэл өгч төрийн байгууллага хоорондын уялдаа зохицуулалтыг хангаж байна. “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (ISF.mn)” системд 08 дугаар сарын 04-ний өдрөөс хуулийн этгээдийн лавлагаа, 08 дугаар сарын 27-ны өдрөөс даатгуулагчийн сүүлийн 36 сарын нийгмийн даатгалын лавлагааны сервисийг холбосон. Тус байгууллагад бүртгэлтэй олон улсын төрийн бус байгууллагын салбар төлөөлөгчийн газруудын мэдээллийг төрийн мэдээлэл солилцооны ХУР системд дамжуулах сервисийг хөгжүүлж, тоон гарын үсэг олгогч байгууллагуудад 08 дугаар сарын 27-ны өдөр хүргүүлснээр 12 дугаар сарын 05-ны өдрийн	100		

1	2	3	4	5	6	7	8
				байдлаар нийт 83 байгууллагаас 30 байгууллага нь тоон гарын үсэг авч ашиглаж эхэлсэн байна. FS100115_NonGovernmentHeadInfo			
59.	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэл 2025-08-06 Дугаар 2025_11	8.1.2	8.1.2. Бүсийн зөвлөлийн болон Засгийн газрын өргөтгөсөн хуралдааныг бүсийн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн, тухайн бүсээс сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд, орон нутгийн удирдлага, иргэдийн санал, оролцоог ханган, төсвийн хэмнэлтийн горимоор, урлаг, спортын, шаардлагагүй бусад арга хэмжээгүй зохион байгуулахыг холбогдох Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Байгууллагын нэгдсэн хурал, зөвлөгөөн, сургалтыг төсвийн хэмнэлтийн горимоор, цахим хэлбэрээр голлон зохион байгуулж байна.	100		
Хэсгийн дундаж: 99.5 хувь							
Засгийн газрын албан даалгавар							
60.	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2025-03-06 Дугаар 2025_02	4.10.5.	Төрийн албаны шинэчлэлийг эрхлэх салбарын хүрээнд манлайлан хууль сахиулах байгууллагын албан хаагчдын сахилга, хариуцлагыг өндөржүүлэх, тус салбар дахь хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Төрийн албаны шинэчлэлийн хүрээнд Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Шинэтгэлээр түүчээлсэн салбар зөвлөл” аяныг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 02 дугаар сарын 24-ний өдөр батлан хэрэгжилтийг хангаж байна. “Төрийн байгууллагын мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт, хөгжлийн бодлогын хэрэгжилт, үр дүн” сэдэвт хүний нөөцийн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 03 дугаар сарын 12-ны өдөр баталж, хэрэгжилтийн явц 11 дүгээр сарын байдлаар 85 хувьтай бөгөөд хуваарийн дагуу гүйцэтгэлийг 12 дугаар сарын 20-ны өдөр Төрийн албаны зөвлөлд тайлагнана. Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцоор баталгаажуулсан хүний эрхийн эсрэг халдашгүй чөлөөтэй байх болон бусад эрхийг	100		

1	2	3	4	5	6	7	8
				зөрчсөн үйлдэл албан хаагчдын зүгээс тайлант хугацаанд гаргаагүй. Төрийн албан хаагчдын сахилга, хариуцлагыг өндөржүүлэх хүрээнд албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн төрийн тусгай албаны удирдах 2, гүйцэтгэх 15 албан хаагчид Төрийн албаны тухай хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл ногдуулсан. Албан даалгаврын хэрэгжилтийг хангаж тайланг 03 дугаар сарын 25-ны өдрийн 01/622 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. https://edoc.mojha.gov.mn/			
61.	Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай 2025-06-18 Дугаар 2025_01	1.1	Шинжлэх ухааны судалгаа, нотолгоонд суурилсан шийдвэр гаргаж, ард иргэдээ сонсон, итгэл, хүлээлт, шаардлагад нь нийцэж ажиллах	Хөгжингүй орны цагаачлалын салбарын сайн туршлагаас суралцах, шинжлэх ухааны судалгаа, нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих зорилгоор БНСУ-ын Олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны байгууллага (KOICA)-тай хамтарсан төслийн хүрээнд 2025 оны 07 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн нэг жилийн хугацаатайгаар тус улсаас зөвлөх мэргэжилтнийг урьж, ажиллуулж байна. Иргэдээ сонсон тэдний санал, хүсэлтэд тулгуурлан үйл ажиллагаагаа сайжруулах, шаардлагад нийцэж ажиллах зорилгоор “Гадаадын иргэн, харьяатын газрын иргэдтэй уулзах хуваарь”-ийг баталж, иргэдэд нээлттэй байдлаар үйлчилгээний танхимд байрлуулан мөрдөж байна. Энэ оны 11 дүгээр сарын өссөн дүнгээр иргэдээс 954 санал хүсэлт, өргөдөл, гомдлыг бичгээр, цахим шуудангаар, утсаар хүлээн авч, 928 өргөдлийг шийдвэрлэн, хуулийн хугацаандаа шийдвэрлэх шатанд 26 өргөдөл хянагдаж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 97.2 хувьтай. Өргөдөл, гомдлын тайланг байгууллагын цахим хуудаст сар бүр мэдээлж байна. Түүнчлэн Монгол Улсын виз, визийн хугацааны сунгалт, албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл, түүний сунгалт, түр ирэгчийн бүртгэл, хасалт, бүртгэлийн дугаарын олголт, ашиглалт, оршин суух үнэмлэх олгох, хэвлэх, төлбөрийн буцаалт,	100		

1	2	3	4	5	6	7	8
				зөрчил шалган шийдвэрлэлт, иргэний харьяаллын асуудлаар энэ оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 87245 иргэнд утсаар, 4646 иргэнд биечлэн, 5699 иргэнд цахимаар, нийт 97590 зөвлөгөө, мэдээлэл өгсөн байна. https://immigration.gov.mn/mn/			
62.		1.2	Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг ханган салбарын удирдлагын манлайллыг мэргэжлийн түвшинд хариуцлагатай хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж ажиллах	Тайлант хугацаанд албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гомдол, санал байхгүй болно. Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөөний дагуу 2025 оны 11 дүгээр сарын байдлаар ёс зүйн чиглэлээр 6 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 423 албан хаагчийг хамрууллаа.	100		
63.		1.3	Яам, харьяа агентлаг, байгууллага, салбарын хэмжээнд сахилга, хариуцлагыг өндөржүүлж, бүх шатанд төсвийн хэмнэлтийн горимыг сахин үр ашиггүй зардлыг танах, төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийн давхардлыг арилгаж, орон тоог үе шаттай цөөлөх	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар 2025 онд 20,757.2 сая төгрөгийн төсөв батлагдсан боловч тус хуульд өөрчлөлт оруулж, төсвийн тодотголоор 18,844.1 сая төгрөгөөр баталсан. Энэ оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 14,523.0 сая төгрөгийн санхүүжилт авснаас төсвийн хэмнэлтийн горимыг сахин зориулалтын дагуу, үр ашигтай зарцуулж 14,357.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан. https://shilendans.gov.mn/ Байгууллагын орон тоо нэмэгдүүлэхтэй холбоотой шийдвэр гаргаагүй, өндөр насны тэтгэвэр тогтоолгож, төрийн албанаас чөлөөлөгдсөн төрийн үйлчилгээний ангиллын 1 албан хаагчийн болон сул орон тоонд нөхөн томилгоо хийгээгүй, албан ажлын зайлшгүй шаардлагаар хилийн боомт, орон нутаг дахь нэгжид 4 төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэн ажиллуулсан. Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсанд нээлттэй байршуулсан төрийн тусгай албаны гүйцэтгэх 13 албан тушаалын сул орон тооны 2 удаагийн тусгай шалгалтыг байгууллагын даргын 06 дугаар сарын 20-ны өдрийн 01/1187 дугаар албан бичгээр санал хүргүүлж, хойшлуулан хүлээгдэж байна. https://csc.gov.mn/	100		

1	2	3	4	5	6	7	8
64.		1.4	Салбарын хэмжээнд ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх төлөвлөгөө гарган цахим шилжилтийг эрчимжүүлэх, салбарын онцлогт нийцсэн инновац, шинэ технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн шийдвэр гаргалтад хиймэл оюун ухаан, их өгөгдлийг ашиглах	Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөө болон 2025 оны 04 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 07 дугаар сарын 09-ний өдөр, 08 дугаар сарын 04-ний өдөр тус тус баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хиймэл оюун (AI)-д суурилсан чатботыг “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (ISF.mn)” систем болон байгууллагын сайт (immigration.gov.mn)-д 08 дугаар сарын 26-ны өдөр холбож үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. https://isf.mn/mn/ Танилт нэвтрэлтийн ДАН системд хиймэл оюунд суурилсан царай танилтын системээр гадаадын иргэнийг бүртгэж баталгаажуулахад виз, оршин суух үнэмлэхийн цээж зургийг ашиглах сервисийн хөгжүүлэлтийг 08 дугаар сарын 27-ны өдөр хийж, сервисийн мэдээллийг и-Монгол академид цахим шуудангаар хүргүүллээ.	100		
65.		1.5	Улс төрөөс ангид чадахуйн зарчимд суурилсан, хүртээмжтэй, шуурхай, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлж, хүнд суртал, шат дамжлагыг эрс бууруулах бодитой ажлыг зохион байгуулан тодорхой ахиц гаргаж, үр дүнг тайлагнах	Улс төрөөс ангид чадахуйн зарчимд суурилсан, хүртээмжтэй, шуурхай, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлж хүрээнд хууль тогтоомж зөрчиж, төрийн жинхэнэ албан хаагчийг чөлөөлөх, халах, албан тушаал бууруулах аливаа шийдвэр гаргаагүй. Төрийн албаны шинэчлэлийн хүрээнд Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Шинэтгэлээр түүчээлсэн салбар зөвлөл” аяныг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдөр батлан хэрэгжилтийн тайланг 06 дугаар сарын 16-ны өдрийн 01/1160 дугаар албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Хүнд суртал, шат дамжлагыг эрс бууруулах зорилгоор байгууллага өөрт байгаа буюу нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байхад анхаарч, иргэдэд чирэгдэл үүсгэхгүйгээр үйл	100		

1	2	3	4	5	6	7	8
				ажиллагааг цахимд шилжүүлэн 31 төрлийн үйлчилгээ үзүүлж байна. Монгол Улсын виз олгох журмын дагуу цахим визийн мэдүүлгийг 48 цагийн дотор хянан шийдвэрлэхээр заасан ч гадаадын иргэнд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй хүргэх зорилгоор визийн хүсэлтийг 5 минутаас 24 цагийн дотор шуурхай шийдвэрлэж байгаа болно. “Телко коммуникейшнс” ХХК-тай 24/1074 дугаар үйлчилгээ үзүүлэх гэрээг 2024 онд байгуулж, хэрэглэгчийн 1800-1882 тусгай дугаарыг иргэдэд өгөх зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээний чиглэлээр ажиллуулж эхэлсэн ба зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээнд AI чатботыг 08 дугаар сараас эхлэн нэвтрүүлээ. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамтай 2025 онд байгуулсан 3 гэрээний үндсэн дээр 6 байгууллагын 32 төрлийн сервисээр мэдээлэл авч, 25 байгууллагад 13 сервисээр мэдээлэл өгч байна.			
66.		1.6	Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх бодитой арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Гадаадын иргэн, харьяатын газар нь улсын хилээр нэвтрэх гадаадын иргэнд виз, визийн зөвшөөрөл олгох, бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх, виз болон оршин суух зөвшөөрөлтэй холбоотой зөрчлийг илрүүлэх, хянан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлэхээс гадна гадаад улсын иргэн Монгол Улсын харьяат болох, Монгол Улсын иргэн харьяатаас гарах, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт зөвшөөрөл олгох, гадаадын иргэн, гэр бүлд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх чиг үүргийг гүйцэтгэдэг, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй төрийн захиргааны байгууллага тул гэрээний үндсэн дээр төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх хэрэгцээ, шаардлага гарахгүй, тэдний чиг үүрэгтэй ажлын давхардал үүсдэггүй болно.	100		2022-09-14 Дугаар 2022_340 давхардсан
67.		1.7	Салбарын хэмжээнд нэн тулгамдсан, шийдвэрлэх	Байгууллагын хэмжээнд тулгамдсан, шийдвэрлэх шаардлагатай асуудлыг тусган Засгийн газрын 100	100		3.10.1

1	2	3	4	5	6	7	8
			зайлшгүй шаардлагатай асуудлыг Засгийн газрын 100 хоногийн төлөвлөгөөнд тусгуулан, шуурхай шийдвэрлэх	хоногийн төлөвлөгөөнд саналыг 06 дугаар сарын 23-ны өдрийн 01/1198 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Байгууллагаас хүргүүлсэн санал Засгийн газрын төлөвлөгөөнд тусгагдан батлагдаагүй ч Засгийн газрын 100 хоногт хэрэгжүүлсэн онцлох арга хэмжээний тайланг 09 дүгээр сарын 18-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яаманд цахимаар хүргүүлсэн. Түүнчлэн Хууль зүй, дотоод хэргийн сайдаас Монгол Улсын Ерөнхий сайдад салбарын хэрэгжүүлсэн онцлох ажлыг танилцуулах мэдээлэлд оруулахаар 11 дүгээр сарын 13-ны өдөр мөн яаманд цахимаар хүргүүлээ. https://edoc.mojha.gov.mn/			
68.		1.8	Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаанд оролцох журмыг чанд мөрдөж, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгүүдтэй нягт уялдаатай ажиллах, хүндэтгэлтэй хандах	Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаанд оролцох журмыг чанд мөрдөж, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгүүдтэй нягт уялдаатай ажиллах, хүндэтгэлтэй хандан ажиллаж байна.	100		
69.		2.1	Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал болон бусад хууль тогтоомжийг чанд мөрдөж, зөрчсөн үйлдэл гаргахгүй байх	Албан даалгаврын тайлант хугацаанд байгууллагын даргын баталсан удирдамжийн дагуу 16 албан хаагчид холбогдуулан төлөвлөгөөт бус 10 удаагийн дотоод хяналт шалгалт явуулж, Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль тогтоомж зөрчсөн 3 албан хаагчид сахилгын шийтгэл оногдуулж, 2 албан хаагчийн ёс зүйн хариуцлагын талонд сануулах арга хэмжээ авсан. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж, Засгийн газрын 2021 оны 192 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын виз олгох журам”-ын 8.5-д заасныг зөрчин гадаадын иргэнд виз олгож, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргээ хэрэгжүүлэх, хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх төрийн албан хаагчийн нийтлэг үүргээ хэрэгжүүлээгүй хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн 1 төрийн жинхэнэ албан хаагчид Төрийн албаны тухай хууль	100		

1	2	3	4	5	6	7	8
				тогтоомжийн дагуу “төрийн албанаас халах” сахилгын шийтгэл ногдуулсан байна. https://hrm.csc.gov.mn/ Авлигын эсрэг хууль тогтоомжийг эрчимжүүлэх, төрийн албан хаагчийг албаны чиг үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан авлигад өртөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах зорилгоор “Авлига, ашиг сонирхлын нөлөөллийг мэдээлэх заавар”-ыг 10 дугаар сарын 01-ний өдрийн А/440 дүгээр тушаалаар, байгууллагын даргын 2025 оны “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” 02 дугаар албан даалгаврыг тус тус батлан хэрэгжүүлж, танилцуулах сургалтыг 10 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулан албан хаагчдаар баталгаа гаргууллаа.			
70.		2.2	Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг зохих журмын дагуу ил болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг зохих журмын дагуу ил болгох арга хэмжээний бэлтгэл ажлын хүрээнд Тагнуулын ерөнхий газраас ирүүлсэн чиглэлийн дагуу Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-ыг баримтлан байгууллагын даргын 05 дугаар сарын 15-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/225 дугаар тушаалаар нууцад байгаа албан бичигт үзлэг хийх ажлын хэсгийг байгуулсан. Үзлэгийг 05 дугаар сарын 19-өөс 22-ны өдрүүдэд зохион байгуулж, төрийн болон албаны нууцын талаарх мэдээллийг 06 дугаар сарын 25-ны өдөр Тагнуулын ерөнхий газарт хүргүүлээ. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-д тус байгууллагад хамаарах мэдээлэл хуульд заасан шалгуур хангаж байгаа эсэхэд шинжилгээ хийж 11 дүгээр сарын 25-ны өдрийн 01/2125 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.	100		

1	2	3	4	5	6	7	8
71.		2.3	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээллийг байнга ил тод нээлттэй байлгах үүргийн биелэлтэд харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд тогтмол хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох	Гадаадын иргэн, харьяатын газар чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний талаарх мэдээллүүдийг сар тутам тогтмол ил тод, нээлттэй байршуулж, гуравдугаар улирлын нээлттэй мэдээллийн түгээлт 94 хувиар үнэлэгдсэн. Мөн Засгийн газрын 2024 оны 96 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй өгөгдлийн жагсаалт”-ын дагуу мэдээлэл хариуцагчийн сар бүр нийтлэх 11 төрлийн өгөгдлийг XLSX, CSV, JSON өргөтгөлөөр боловсруулж, сар бүрийн өгөгдлийг төлөвлөгөөний дагуу дараа сарын 10-ны өдрийн дотор байгууллагын цахим хуудас болон Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем (opendata.gov.mn)-д тус тус нийтэлж байна. Түүнчлэн байгууллагын даргын 2025 оны 01-08/06, 01-08/10 дугаар удирдамжийн дагуу төв болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдийн Шилэн дансны тухай хуулийн энэ оны 2, 3 дугаар улирлын хэрэгжилтэд дотоод аудит хийн Санхүү, хангалт үйлчилгээний газар, орон нутаг дахь нэгжүүдэд зөвлөмж хүргүүлсэн.	100		
72.		2.4	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх, таслан зогсоох, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглахгүй байх, төрийн	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Эрсдэлд суурилсан авлигын эсрэг төлөвлөгөөг тус тус батлан хэрэгжүүлж, хагас жилийн биелэлтийг “Авлигын эсрэг үндэсний сүлжээ” цахим системд баталгаажуулан Авлигатай тэмцэх газарт илгээсэн. Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх 3 төлөвлөгөө, 1 чиглэлийн хэрэгжилт 90 хувьтай. Авлигын эсрэг хууль тогтоомжийг эрчимжүүлэх, төрийн албан хаагчийг албаны чиг үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан авлигад өртөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах зорилгоор “Авлига, ашиг сонирхлын нөлөөллийг мэдээлэх заавар”-ыг А/440 дүгээр тушаалаар, байгууллагын даргын 2025 оны “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан	100		

1	2	3	4	5	6	7	8
			байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг идэвхжүүлэх	сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” 02 дугаар албан даалгаврыг тус тус батлан мөрдөж, танилцуулах сургалтыг 10 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулан албан хаагчдаар баталгаа гаргуулсан. Тайлант хугацаанд авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон байж болзошгүй 1 албан хаагчид хууль тогтоомжийн дагуу төрийн албанаас халах сахилгын шийтгэл ногдууллаа. Гадаадын иргэн, харьяатын газрын Ёс зүйн дэд хороог байгууллагын даргын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/85 дугаар тушаалаар байгуулж, хууль тогтоомжийн дагуу 05 дугаар сарын 01-ний өдрөөс нарийн бичгийн даргад сар бүр, дарга, гишүүдэд улирал тутам урамшуулал олгож байна. Хилийн боомт, орон нутаг дахь нэгжид ажиллах байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэдээлэл солилцох, уялдаа холбоо, зохицуулалтыг хангах, тайлагнах чиг үүрэг бүхий албан хаагчдыг байгууллагын даргын 2025 оны А/106 дугаар тушаалаар 7 нэгжид тус тус томилон ажиллаж байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн 2025 оны тайланг 09 дүгээр сарын 12-ны өдрийн 01/1643 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. https://edoc.mojha.gov.mn/			
73.		2.5	Төрийн албан хаагчийг хууль бусаар томилж, чөлөөлөх, аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлэхгүй байх	Төрийн албан хаагчийг хууль бусаар томилж, чөлөөлсөн, аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлсэн зөрчил илрээгүй ба тайлант хугацаанд Төрийн албаны тухай хуулийн 44.1, 44.5 дахь заалтыг тус тус үндэслэн байгууллагын нэгж хооронд 1, төрийн бусад байгууллагаас 1, нийт 2 албан хаагчийг 07 дугаар сард шилжүүлэн ажиллуулсан бол эхний 11 сарын дүнгээр байгууллагын нэгж хооронд 27, төрийн бусад байгууллагаас 13 албан хаагч шилжүүлэн ажиллуулж, урт хугацаанд суралцах хүсэлт ирүүлсэн	100		

1	2	3	4	5	6	7	8
				6, эмчлүүлэх 3 албан хаагчийг төрийн албанаас түр чөлөөлсөн. https://hrm.csc.gov.mn/			
74.		2.6	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, тансаглалыг таслан зогсоох талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт орж, төсвийн тодотголоор 18,844.1 сая төгрөгийн төсөв батлагдсантай холбогдуулан Хилийн боомт, орон нутаг дахь төсвийн шууд захирагч нарт батлагдсан төсөвт багтаан өр, авлага үүсгэхгүй ажиллахыг үүрэг болгон 2025 оны 01/1504, 01/1505, 01/1506, 01/1507, 01/1508, 01/1509, 01/1510 дугаар албан бичгийг тус тус хүргүүлсэн. Төсвийг сар, улирлаар хянаж, өр үүсэж байгаа зарим зардалд хуваарийн өөрчлөлтийн саналыг 2025 оны 01/490, 01/813, 01/1015, 01/1499, 01/1698, 01/1861, 01/2091 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, холбогдох зардлуудыг шийдвэрлүүлсэн. https://edoc.mojha.gov.mn/	100		
75.		3.2	Ерөнхий сайдын өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангаж, үр дүнг тухай бүр тайлагнах, биелүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох	Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх байгууллагын төлөвлөгөөг 07 дугаар сарын 09-ний өдөр баталж, хэрэгжилтэд хяналт тавин үр дүнг дээд шатны байгууллагад хугацаанд нь тухай бүр тайлагнан ажилласан. Ерөнхий сайдын үүрэг, даалгаврыг хангалтгүй биелүүлсэн болон үр дүнг хугацаанд нь тайлагнаагүй албан тушаалтан байхгүй болно. https://edoc.mojha.gov.mn/	100		
76.		3.3	Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн, танилцуулсан, эрхлэх ажлын хүрээнд хамаарах асуудлыг бүрэн хариуцаж, гарсан шийдвэр, үр дүнгийн талаар олон нийтэд үнэн зөв, бодитой мэдээлэл өгч байх	Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн, танилцуулсан, эрхлэх ажлын хүрээнд хамаарах асуудлын талаар гарсан шийдвэр, үр дүнгийн мэдээллийг байгууллагын цахим хуудас, shilen.gov.mn болон олон хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим сайтуудаар дамжуулан олон нийтэд үнэн зөв өгч байна. Монгол Улсыг 2025-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, бодлогын баримт бичгийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг өргөн мэдүүлсэнтэй холбогдуулан “Зөв засаглалын үзүүлэлтийг нэмэгдүүлнэ” бодлогын зорилгын таван	100		

1	2	3	4	5	6	7	8
				жилийн салбарын хөгжлийн төлөвлөгөөнд туссан “Цагаачлал, гадаадын иргэний бүртгэлийн үйлчилгээ” хөтөлбөрийн “Гадаадын иргэнд тавих бүртгэл, мэдээлэл, хяналтыг сайжруулна” үр дүнг хэрэгжүүлэх арга зам, арга хэмжээний талаар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан нэгдсэн төлөвлөгөөний дагуу постер мэдээлэл бэлтгэж, байгууллагын цахим хуудаст ил тод, ойлгомжтой байдлаар байршуулан олон нийтэд хүргэлээ. https://immigration.gov.mn/mn/ https://shilendans.gov.mn/			
77.		3.4	Энэ албан даалгаврын хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээллийг сар бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлж байхыг Засгийн газрын гишүүдэд, биелэлтэд нь хяналт тавьж, явц, үр дүнг нэгтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогтод тус тус үүрэг болгосугай	Албан даалгаврын хэрэгжилт, үр дүнг тооцон ажиллаж, тайланг сар бүр дээд шатны байгууллагад хүргүүлж байна. Үр дүнгийн 07 дугаар сарын тайланг 02/1373 дугаар, 08 дугаар сарын тайланг 02/1541 дүгээр, 09 дүгээр сарын тайланг хууль тогтоомжийн гуравдугаар улирлын хэрэгжилттэй хамтатган 01/1664 дүгээр, 10 дугаар сарын тайланг 01/1959 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн. https://edoc.mojha.gov.mn/	100		
78.	Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2025-07-25 дугаар 2025_04	1.2	Төрийн албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах арга хэмжээ авч, байгууллагын орон тоог нэмэгдүүлэхтэй холбоотой аливаа шийдвэр гаргахгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоо болон сул орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүй байхыг Засгийн	Тайлант хугацаанд байгууллагын орон тоо нэмэгдүүлэхтэй холбоотой шийдвэр гаргаагүй, өндөр насны тэтгэвэр тогтоолгож, төрийн албанаас чөлөөлөгдсөн төрийн үйлчилгээний ангиллын 1 албан хаагчийн болон сул орон тоонд нөхөн томилгоо хийгээгүй, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсанд нээлттэй байршуулсан төрийн тусгай албаны гүйцэтгэх 13 албан тушаалын сул орон тооны 2 удаагийн тусгай шалгалтыг байгууллагын даргын 06 дугаар сарын 20-ны өдрийн 01/1187 албан бичгээр санал хүргүүлж, хойшлуулан хүлээгдэж байна. www.csc.gov.mn	100		

1	2	3	4	5	6	7	8
			газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад	Мөн дээд шатны байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн чиглэл, үүрэг даалгаврын хүрээнд салбарын яамны бүтцийн нэгжийн оноосон нэр, хариуцах чиг үүрэгтэй байгууллагын зохион байгуулалтын нэгжийн нэрийн болон чиг үүргийн давхардал болон удирдах албан тушаалтны эзлэх хувьд харьцуулсан судалгаа хийхэд салбарын яамны 7 газар, 6 хэлтсийн оноосон нэр болон чиг үүргийн давхцал байхгүй, албан тушаалын төрлөөр нийт албан хаагчдын 20 буюу 6,3 хувийг удирдах албан тушаалтан эзэлж байгаа нь Монгол Улсын Төрийн албаны 2024 оны төрийн тусгай албан хаагчийн нэгдсэн тоо бүртгэлийн дүн, улсын дундажтай харьцуулахад удирдах албан тушаалтны эзлэх хувь 2,7 хувь төрийн жинхэнэ албаны дүнгээр 4 хувиар тус тус бага байгааг судалсан дүнг 09 дүгээр сарын 15-ны өдрийн 01/1656 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлсэн.			
79.		1.3	Иргэддээ чин шударгаар үйлчилдэг, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэх зорилгод нийцүүлэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг чанд мөрдүүлэх, хуулийг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг төрийн бүх шатны удирдлагад	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хүрээнд хилийн боомт, орон нутаг дахь нэгжид ажиллах байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэдээлэл солилцох, уялдаа холбоо, зохицуулалтыг хангах, тайлагнах чиг үүрэг бүхий албан хаагчдыг байгууллагын даргын 2025 оны А/106 дугаар тушаалаар томиллоо. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг чанд мөрдүүлэх хуулийг сурталчлан таниулах зорилгоор байгууллагын даргын 2025 оны А/118 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу 03 дугаар сарын 31-ний өдөр Агаарын замын боомт хариуцсан газарт, 04 дүгээр сарын 08-аас 10-ны өдрүүдэд Дорноговь аймаг дахь газарт ажиллаж Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилт, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, албаны чиг үүргээ хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлын талаар хамтарсан уулзалт зохион байгуулав.	100		

1	2	3	4	5	6	7	8
				Тайлант хугацаанд соён гэгээрүүлэх арга хэмжээний хүрээнд “Албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалт” (50 секунд), “Төрийн албан хаагчид хориглох зүйл” (60 секунд), Авлигын хор хөнөөлийг таниулсан контент (1 минут 4 секунд)-ыг байгууллагын цахим хуудаст байршуулж олон нийтэд мэдээллээ. https://immigration.gov.mn/mn/ Төрийн албан хаагч бүрийг ёс зүйтэй, шударга ажиллах үүргээ сайтар ухамсарлан ойлгож, чанд мөрдөхөд чиглүүлэн ёс зүйн асуудал хариуцсан албан тушаалтантай харилцах, холбогдох зөвлөгөөг авах талаарх мэдээллийг сурталчилгаа, сургалт, санамж байдлаар биечлэн болон төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системээр дамжуулан нийт албан хаагчдад тогтмол хүргэн ажиллаж, тэдний ойлголт мэдлэгийг бататгах хүрээнд ёс зүйн тухай хууль тогтоомжийн мэдлэгийг шалгах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 03 дугаар сард 104 албан хаагчийг сорилд хамруулан түүний мөрөөр зөвлөмж өгсөн нь нийт албан хаагчийн 33 хувийг эзэлж байна.			
80.		1.4	Төрийн байгууллагын ёс зүйн дэд хороог 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор гүйцээн байгуулж ажиллуулахыг бүх шатны төрийн байгууллагын удирдлагад	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг байгууллагын даргын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/85 дугаар шинэчлэн баталж, хууль тогтоомжийн дагуу 05 дугаар сарын 01-ний өдрөөс нарийн бичгийн даргад сар бүр, дарга, гишүүдэд улирал тутам урамшуулал олгож байна. Ёс зүйн дэд хороог байгууллагын төв болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн нийт албан хаагчдыг оролцуулсан цахим санал асуулгын дүнгээр хамгийн олон санал авсан 7 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй байгуулж, дэд хорооны даргаар Зөрчил шалган, шийдвэрлэх газрын хяналтын улсын ахлах байцаагч, нарийн бичгийн даргаар Захиргаа, удирдлагын газрын мэргэжилтэн тус тус сонгогдсон ажиллаж байна.	100		3.10.1

1	2	3	4	5	6	7	8
81.		1.7	Төрийн албаны тухай хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албан хаагчдыг төрийн албанаас чөлөөлөхгүй, халахгүй, хуулиар чиг үүрэгт нь өөрчлөлт ороогүй тохиолдолд төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахгүй байх, төрийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөн боловч албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг нь хэвээр хадгалагдан үлдсэн төрийн жинхэнэ албан хаагчдыг чөлөөлөх, халах, албан тушаал бууруулах, шилжүүлэх шийдвэр гаргахгүй байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт	Төрийн албан хаагчийг хууль бусаар томилж, чөлөөлсөн, аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлсэн зөрчил илрээгүй ба албан даалгаврын тайлант хугацаанд Төрийн албан хаагчийг хууль бусаар томилж, чөлөөлсөн, аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлсэн зөрчил илрээгүй ба тайлант хугацаанд Төрийн албаны тухай хуулийн 44.1, 44.5-д заасны дагуу байгууллагын нэгж хооронд 1, төрийн бусад байгууллагаас 1, нийт 2 албан хаагчийг 07 дугаар сард шилжүүлэн ажиллуулсан бол эхний 11 сарын дүнгээр байгууллагын нэгж хооронд 27, төрийн бусад байгууллагаас 13 албан хаагч шилжүүлэн ажиллуулж, урт хугацаанд суралцах хүсэлт ирүүлсэн 6, эмчлүүлэх 3 албан хаагчийг төрийн албанаас түр чөлөөлөн, холбогдох хууль тогтоомж зөрчиж, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргээ хэрэгжүүлээгүй 1 албан хаагчид төрийн албанаас халах сахилгын шийтгэл ногдуулсан. Бусад байдлаар хууль тогтоомж зөрчиж, төрийн жинхэнэ албан хаагчийг чөлөөлөх, халах, албан тушаал бууруулах шийдвэр гаргаагүй болно. https://hrm.csc.gov.mn/ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны А/129 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан зохион байгуулалтын бүтэц, орон тоогоор ажиллаж байгаа бөгөөд хуулиар чиг үүрэгт өөрчлөлт ороогүй тул бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийж, албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулаагүй байна. https://hrm.csc.gov.mn/	100		
82.		1.8	Ажлын байрны нээлттэй мэдээлэлд үндэслэн төрийн албан хаагчдыг хувийн хэвшилд шилжүүлэн ажиллуулах санал боловсруулж, цалин хөлс, нийгмийн баталгааны талаарх мэдээллийг төрийн албан хаагчдад хүргэх	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 52 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан байгууллагын орон тооны дээд хязгаарт өөрчлөлт оруулаагүйтэй холбогдуулан төрийн албан хаагчдыг хувийн хэвшилд шилжүүлэн ажиллуулах талаар уулзалт, арга хэмжээ зохион байгуулах шаардлага үүсээгүй болно.	100		

1	2	3	4	5	6	7	8
			уулзалт, арга хэмжээг Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон холбогдох бусад байгууллагатай хамтран зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт				
Хэсгийн дундаж: 100 хувь							
Нийт дундаж: 97.6 хувь							

--oo0oo--